



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/104

Зуунмод

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 45.7 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолын 5 дугаар хавсралт дахь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Бүрэн суманд ундны усны худаг гаргах, ус шүүх төхөөрөмжийн хамт” төсөл, арга хэмжээг Бүрэн суманд эрх шилжүүлэн гүйцэтгүүлсүгэй.

2.Ундны усны худаг шинээр гаргах, ус шүүх төхөөрөмж суурилуулах ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг Бүрэн сумын Засаг дарга (Д.Эрдэнээ)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны газрын дарга (Ж.Даш-Яйчил)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Л.ТӨМӨРЧӨДӨР

4123010304